



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/УБ

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн заалт, Засгийн газрын 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 4.3.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг үлгэрчилсэн загварын дагуу боловсруулж, батлуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Л.Бат-Октябрь

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Л.Цэнддорж

-Цэргийн штабын офицер

Т.Бямбадулам

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Дээрх Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг үлгэрчилсэн загварын дагуу боловсруулж, тагнуулын хэлтсээс санал авч батлуулах ажлыг хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Л.Бат-Октябрьт даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР